

## **БАТЛАВ.**

# **ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НИЙЦҮҮЛЭН ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ЗОРИЛГООР ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

## **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж, Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг “Монгол Улсын иргэн ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй...” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурал төрөөс иргэдийнхээ аж ахуй үйл ажиллагаа эрхлэх эрхийн баталгааг хангах зорилгоор 2011 онд баталсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг Монгол улсын Үндсэн хуулийн суурь зарчим, хүний эрхийн баталгаанд нийцүүлэн бүхэлд нь шинэчлэн найруулж, 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 35 дугаар тогтоол, 2023 оны 69 дүгээр тогтоолоор салбарын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 06 өдөр эцэслэн баталсан хэдий ч биологийн идэвхит бүтээгдэхүүнтэй холбоотой зарим хууль хоорондын нийцлийг хангаагүйгээс хийдэл, зөрчил үүсээд байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэг “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж заасан.

Тухайлбал Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийн 6 дугаар зүйлд “... 8.1 дүгээр зүйлийн ... 13 дахь хэсгийн 13.16 дахь заалт, ... хүчингүй болсонд тооцсугай” гэсэн бөгөөд энэ нь эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын олгох “биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх” тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцсон.

Өөрөөр хэлбэл биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх зөвшөөрлийг хүчингүйд тооцож, хүн, хуулийн этгээд энэ төрлийн үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхлэх боломж бүрдсэн хэдий ч дээрх өөрчлөлтийн дагуу холбогдох салбар хуульд өөрчлөлтийг тусгаагүйгээс хууль хоорондын зөрчил үүсэж, хэрэглээнд алдаа гарч байгаа талаар иргэн, хуулийн этгээдээс гомдол ирүүлсээр байна.

Ийнхүү тодорхой салбарт хамаарах зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлээгүйгээс тухайн салбарт хэрэгжүүлж байгаа эрх зүйн шинэчлэлийн зорилго болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийн суурь зарчим хангагдах боломжгүй юм.

Иймд холбогдох хууль тогтоомжийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Зөрчлийн тухай болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

## **1.2.Практик шаардлага:**

Зөвшөөрлийн тухай хуулиар хүн, хуулийн этгээдийн “хуулиар хориглосон болон хуульд зөвшөөрөлтэй эрхлэхээр зааснаас бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх” эрхийг баталгаажуулж, төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглосон.

Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Тус хууль нь салбар дундын харилцааг зохицуулж буй учраас Улсын Их Хурлын 2022 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолоор “Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт ... Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, ... Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэсэн чиглэлийг Засгийн газарт өгсний дагуу Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 85 хуулийн төсөл, 1 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьсан.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр эцэслэн баталсан бөгөөд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

Дээрх хуулийн нийцлийг хангах хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлд Зөвшөөрлийн тухай хуулийн “ ... 8.1 дүгээр зүйлийн ... 13 дахь хэсгийн 13.16 дахь заалт ... хүчингүй болсонд тооцсугай” гэсэн бөгөөд энэ нь эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын олгох “биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх” тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцож, өөрөөр хэлбэл Зөвшөөрлийн тухай хуулиар дээрх үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх боломжийг иргэн, аж ахуй нэгжид олгосон байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13 дахь хэсгийн 13.16-д заасан биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцохтой холбоотой зохицуулалтын дагуу Зөрчлийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтийг тусгаагүй өргөн мэдүүлснээс хууль хоорондын зөрчил үүсэж, хуулийн хэрэгжилтэд алдаа гарч, иргэн, хуулийн этгээд эдийн засаг, цаг хугацаагаар хохирсоор байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 69 дүгээр тогтоолын 1.1-д зарим зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсон (биологийн идэвхит бүтээгдэхүүн)-той холбогдуулж салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор

Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн боловч өнөөдрийг хүртлэх хугацаанд тогтоолын хэрэгжилтийг биелүүлээгүй байна.

Иймд тухайлсан хуульд заасан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн зарчим, нийтлэг зохицуулалтад нийцүүлж, өөрчлөх шаардлагатай байна.

Хуулийн төслийг боловсруулахад холбогдох төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон зөвшөөрөл олгох эрхий бүхий этгээдүүд, мөн нийтийн эрх зүйн хуулийн этгээд, мэргэжлийн холбоодоос санал авна.

### **Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэг “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж, 1.5 дугаар зүйлийн 1-д заасан зарчим, мөн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр батлагдсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлд Зөвшөөрлийн тухай хуулийн “ ... 8.1 дүгээр зүйлийн ... 13 дахь хэсгийн 13.16 дахь заалт ... хүчингүй болсонд тооцсугай” гэж заасантай нийцүүлэн биологийн нэмэлт бүтээгдэхүүний харилцаатай холбогдох хуулиудад өөрчлөлтийг тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал**

Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа салбарын хуулиудыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгаснаар уг харилцаатай холбоотой эрх зүйн шинэчлэл хэрэгжих боломж бүрдэнэ.

Түүнчлэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд дэвшүүлсэн “Төрийн хяналт, шалгалтын давхардсан

тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулах” зорилтыг хэрэгжүүлэх бодит нөхцөл хангагдана.

Эрх бүхий этгээдийн хариуцлага сайжирч, авлига, албан тушаалын хэрэг буурч, бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрхийн баталгаа хангагдана.

**Дөрөв.Хуулийн төслийн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж, бусад хуультай уялдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 31, 32 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу боловсруулна.

---oOo---

## ТАНИЛЦУУЛГА

Зөвшөөрлийн тухай хуульд бусад хууль тогтоомжийг нийцүүлэн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан хуулийн төслийн талаар

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагын талаар**

Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлж, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор салбарын 85 хуулийн өөрчлөлтийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хурал баталсан.

Зөвшөөрлийн тухай хуулийг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2022 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолоор “Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт ... Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 69 дүгээр тогтоолоор зарим зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсон (биологийн идэвхит бүтээгдэхүүн)-той холбогдуулж салбарын хууль тогтоомжид оруулах шаардлагатай өөрчлөлтийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт даалгасан хэдий ч өнөөдрийг хүртэлх хугацаанд тогтоолын хэрэгжилт биелээгүй байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэг “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж заасан.

Түүнчлэн тус хуулиар хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон болон зөвшөөрөлтэй эрхлэхээр зааснаас бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх эрхийг баталгаажуулж, улмаар төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглосон.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлд Зөвшөөрлийн тухай хуулийн “ ... 8.1 дүгээр зүйлийн ... 13 дахь хэсгийн 13.16 дахь заалт ... хүчингүй болсонд тооцсугай” гэсэн бөгөөд энэ эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын олгох “биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх” тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцож, өөрөөр хэлбэл Зөвшөөрлийн тухай хуулиар дээрх үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх боломжийг иргэн, аж ахуй нэгжид олгосон байна.

Иймд зөвшөөрөл олгох харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж хоорондын зөрчил, давхардал, хийдлийг арилгах хүрээнд Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж, бусад хуультай уялдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 31, 32 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу боловсруулна.

### **Хоёр.Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, зохицуулалтын давхардал хийдлийг арилгах зорилгын талаар**

Салбар хуулиар зохицуулж байгаа зөвшөөрлийн төрөл, ангиллыг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд нийцүүлж, ингэхдээ уг жагсаалтад тусгагдаагүй, тухайлсан хуульд заасан зөвшөөрөл болон эрх олгох зохицуулалтыг хасаж, хүчингүй болсонд тооцох зохицуулалтыг тусгасан.

Өөрөөр хэлбэл, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлд заасан зарчимд нийцүүлэн тухайлсан хуульд холбогдох өөрчлөлтийг тусгаснаар хуулиас гадуур хүний эрхийг хязгаарладаг зөрчлийг арилгаж, хуулийн хэрэгжилтийн үр нөлөө дээшилнэ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлтэй нийцүүлэн Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 1 дүгээр зүйл, 5 дугаар зүйл, 6 дугаар зүйл, 15 дугаар зүйл, 16 дугаар зүйл, 22 дугаар зүйл, 27 дугаар зүйл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлд холбогдох өөрчлөлтийг тусгасан.